



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 470

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй сэргээн засварлах боломжгүй болсон нийт 41,032,329.02 /дөчин нэгэн сая гучин хоёр мянга гурван зуун хорин есөн төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн балансын үнэ, 994,098.68 /есөн зуун ерэн дөрвөн мянга ерэн найман төгрөг жаран найман мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 3 ширхэг барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0000973

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2019 оны 41 дугаар сарын 19-ний өдрийн
 410 дугаар тогтоолын хавсралт



Иргэний нисэхийн ерөнхий газрын
 үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлах барилга

Д/д	Хөрөнгийн нэр	но носоо орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Агуулахын байшин 347	1981/ 1994.10.01	Хан-Уул дүүрэг 10 дугаар хороо	10,285,311.17	514,265.56	9,771,045.61
2	Ногоон зоорь 348	1981/ 1996.07.01	Хан-Уул дүүрэг 10 дугаар хороо	14,682,768.55	319,190.62	14,363,577.93
3	2 өрөө сууц	1966/ 2001	Говь-Алтай аймгийн Есенбулаг сумын Алтай хороо	16,064,249.30	160,642.50	15,903,606.80
	Нийт дүн			41,032,329.02 /дечин нэгэн сая гучин хоёр мянга гурван зуун хорин есөн төгрөг хоёр мөнгө/	994,098.68 /есөн зуун ерэн дөрвөн мянга ерэн найман төгрөг жаран найман мөнгө/	40,038,230.34 /дечин сая гучин найман мянга хоёр зуун гучин төгрөг гучин дөрвөн мөнгө/